## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН
## ЗАХИРАМЖ

2014 оны 03 сарын 24 өдөр Дугаар 48 Улаанбаатар хот

**Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн**
**хуралдааны цагийг өөрчлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааныг долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт өглөө 09 цагаас эхэлж, үдээс хойш 14 цагаас үргэлжлүүлж байхаар тогтоосугай.

2.Энэ захирамжид заасан цагийн хуваарьт нийцүүлэн ажлаа зохион байгуулахыг Байнгын хороодын дарга, гишүүд болон Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА З.ЭНХБОЛД

0000000172